

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оныдугаар
сарын ...-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, "Хэнтий-Ус" ХХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 08-ний өдрийн 219 дүгээр албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Хэрлэн сум, Батноров сумын Бэрх тосгоны төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Хэнтий-Ус" ХХК (Д.Хүрэлбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газрын дарга (Б.Эрдэнэбулган)-д даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 497 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
.....дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМ БОЛОН БАТНОРОВ СУМЫН
БЭРХ ТОСГОНЫ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ
ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Хэнтий аймгийн Хэрлэн сум, Батноров сумын Бэрх тосгоны хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		төг/м ³	2,700.0
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	төг/ГЖ	42,195.0
		тогтмол	төг/м ³	1,400.0
3	Төсөвт байгууллагын хэрэгцээний ус халаасан дулаан		төг/м ³	5,200.0

*Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
.....дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМ БОЛОН БАТНОРОВ СУМЫН
БЭРХ ТОСГОНЫ ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ
ӨРХӨД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Хэнтий аймгийн Хэрлэн сум, Батноров сумын Бэрх тосгоны хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		төг/м ³	2,500.0
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	төг/ГЖ	42,178.0
		тогтмол	төг/м ³	1,350.0
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээний ус халаасан дулаан		төг/м ³	5,200.0
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, “00”-ын өрөөний халаалт хамаарна)		төг/м ²	1,300.0
5	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан		төг/м ³	5,000.0
6	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м2 хүртэлх талбайтай айл өрх	төг/сар	3,000.0
		41 м2-ээс 80 м2 хүртэлх талбайтай өрх	төг/сар	5,000.0
		81 м2-ээс дээш талбайтай айл өрх	төг/сар	10,000.0